# Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний ХШҮ-ний тайлан

## Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

## 2023 оны хагас жил

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл | 1.1.1. Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан эрт илрүүлэг үзлэгийг чанаржуулах | | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь | 60 | | Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 0-17 насны 17141 хүүхэд буюу 51.3 хувьтай, 18-аас дээш насанд 6565 буюу 11.7 хувьтай хамрагдсан үзүүлэлттэй байна. Манай аймгийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт улсын дундажаас 3,9 хувиар бага аймгуудын дундажаас 2,4 хувиар бага байна. Насны ангилалаар авч үзвэл: 0-17 насанд аймгийн дундажаас 4 хувиар бага улсын дундажаас 3 хувиар их, 18-45 насанд улс аймгийн дундажаас 5-9 хувиар бага, 46 дээш насанд аймгийн дундажаас 2-4 хувиар их улсын дундажаас 5 хувиар бага үзүүлэлттэй байна. Өвчлөлөөр нь авч үзвэл 18-34 насны иргэдэд бөөр шээс дамжуулах замын эмгэг, цөсний үрэвсэл, ходоодны өнгөц үрэвсэл, 35-64 насны иргэдэд цөсний замын эмгэг, бөөр шээс дамжуулах замын эмгэг, дотоод шүүрлийн эмгэг, ходоодны өнгөц үрэвсэл зонхилон тохиолдож | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Иймд эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж ажиллах 2 сарын аяны төлөвлөгөөг гарган нэгжүүдэд хүргүүлж хяналт тавин ажиллаж байна | |
| 2 | | 1.1.2.. Улсын чанартай автозам бүхий сумдын Эрүүл мэндийн төвийг түшиглэн яаралтай тусламж, осол гэмтлийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэх баг байгуулж үйл ажиллагааг өргөжүүлэх | | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 60 | | Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн их эмч, 2 сувилагчийг яаралтай тусламжийн төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад хамруулсан. 2022 онд ДЭМБ-ийн санхүүжилтаар 15 сая төгрөгийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангасан. Цаашид Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийг түшиглэн яаралтай тусламж, осол гэмтлийн чиглэлээр ажлын байрны сургалтыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөж байна. | |
| 3 | | 1.1.3. Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | | Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдээр эрт илрүүлэг үзлэгт 6-17 насны 12434 (58%) хүүхдийг амны хөндийн үзлэгт хамруулсан. Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетаар эхний 5 сарын байдлаар 1070 хүүхдэд амны хөндийн үзлэг хийж, 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд шүдний хувийн хэвшлийн 6 эмнэлэг 2023 оны эхнии 5 сарын байдлаар ерөнхий боловсролын сургуулийн 6-15 насны 812 хүүхдэд үзлэг хийж, өвчлөл илэрсэн 345 хүүхдийг 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн байна. Үзлэг оношлогоонд хамрагдсан хүүхэд багачуудад амны хөндийн эрүүл ахуйг сахих, шүдээ зөв угаах дадлын талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байна. | |
| 4 | | 1.1.4. Багийн эмч нарын мотоциклийг үе шаттайгаар шинэчлэх | | Мотоциклоор хангагдсан эмчийн тоо | 17 | | Аймгийн хэмжээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 33 багийн эмчийн мотоциклийг үе шаттайгаар шинэчлэсэн. 2023 онд өмнөх оны үлдэгдэл 46.0 сая төгрөгийн төсөвт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өртөгтэй 16 ширхэг мотоциклийг Эрүүл мэндийн газрын судалгаанд үндэслэн 06 сарын 12-нд багийн эмч нарт гардуулахаар ажиллаж байна. | |
| 5 | | 1.1.5. Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн лабораторын тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах | | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 85 | | Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар Улсын төсвийн 312.0 сая төгрөг төсөвт тусгагдсанаас нэгжийн үнэ 15.0 сая, нийт үнэ 180.0 сая төгрөгний өртөгтэй гематлогийн анализаторыг 12 сум, өрхийн эрүүл мэндийн төвд нийлүүлсэн. Тус онд үлдэгдэл санхүүжилт болох 132.0 сая төгрөгний биохимийн бүрэн автомат 6 ширхэг анализаторыг 2023 оны 07 дугаар сард нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Рейсинг мед” ХХК-тай хамтран ажиллаж байна. | |
| 6 | | 1.1.6. Шаардлагатай сумдын ЭМТөвийн түргэн тусламжийн автомашиныг парк шинэчлэлт хийх | | Шинэчилсэн автомашины тоо | 3 | | Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв УАЗ пургон автомашинаар, Шаргалжуут тосгоны Эрүүл мэндийн төв Ланд автомашинаар хангагдаж, иргэдэд яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг хэвийн үзүүлэх боломж бүрдээд байна. Мөн Биологийн олон янзын дасан зохицох төслийн хүрээнд Богд, Баян-Өндөр, Баянлиг сумын Эрүүл мэндийн төвүүдэд туулах чадвар сайтай түргэн тусламжийн автомашин нийлүүлэхээр төлөвлөгдсөн. Одоогоор олгогдоогүй байна. | |
| 7 | | 1.1.7. "Жаргалтай амьдрал төв"- ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | | Үйлчлүүлэгчийн тоо | 100 | | 2023 оны эхний 5 сарын байдлаар нийт 41 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэн хордлого шарталтыг тайлах болон сэтгэлзүйн эмчилгээ хийж, одоогоор 79 хувийн үр дүнтэй ажиллаж байна. Нийт 41 үйлчлүүлэгчээс 38 эрэгтэй, 3 эмэгтэй үйлчлүүлэгч байна. "Архинд донтох эмгэгийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэл | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тодорхойлох” хэлэлцүүлгийг 2023 оны 05 сарын 01-ний өдөр “Жаргалтай амьдрал” төвтэй зохион байгуулж, хамтын ажиллагааны хүрээнд “Санамж бичиг” байгуулсан. Архи, согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбоотой үүссэн асуудалд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, хамтын ажиллагааны ажлын төлөвлөгөө, зураглалыг гарган хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгчдийн биеийн байдлыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/814 дүгээр тоот тушаалийн дагуу үнэлэн, эрэмбэлж ХӨХ, УЛААН, ШАР эрэмбээр эрэмбэлэгдсэн үйлчлүүлэгчдийг Нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн яаралтай тусламж үзүүлэх журмыг мөрдөж, хамтран ажиллаж байна. Одоогоор Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагт архинд донтох эмгэгээр 45 эмчлүүлсэн байна. | |
| 8 | | 1.1.8. Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын байрыг шинээр барих | | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 60 | | | Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын албаны байрыг шинээр барих зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна. 2024 оны улсын төсөв, сайдын багцуудад тус барилгыг барихад шаардлагатай хөрөнгийг тусгуулахаар, тодотголоор оруулахаар саналыг хүргүүлсэн. | |
| 9 | | 1.1.9. Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах | | Хэрэгжилтийн хувь | 100 | | | “Оточ номгон” өрхийн Эрүүл мэндийн төвийн барилгын тендерт “Базардарь” ХХК 827,752,000 төгрөгийн төсөвт өртгөөр шалгарч, барилгын явц 90.0 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогоор орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөгийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэж, гадна зогсоол, ногоон байгууламж, бусад тохижилт, инженерчлэлийн шугам сүлжээний ажлууд хийгдэхээр барилгын ажил үргэлжилж байна. | |
| 10 | | 1.1.10. Галуут сумын Эрүүл мэндийн төвийн хуучин Халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувилалын төв болгох | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Галуут сумын Эрүүл мэндийн төвийн хуучин Халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувилалын төв болгох ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулалтын ажлыг 2022 онд зохион байгуулж, Ар жаргалант ХХК-тай гэрээ байгуулсан. Ажлын явц 90%-тай үргэлжилж байна. Тус ажил нь 06 дугаар сард ашиглалтад орно. | |
| 11 | | 1.1.11. Заг сумын Эрүүл мэндийн төвийн Халдвартын эмнэлгийг стандартад нийцүүлэн засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Заг сумын эрүүл мэндийн төвийн 2 блок дээврийн засварын гүйцэтгэгчээр “Жаргалтай Хөх Тариа” ХХК шалгарч нийт 87.0 сая төгрөгний гэрээний дүнгээр 2 блокын дээврийн засвар,морог, гараш, халдвартын тасгийн засварыг хийхээр шалгарч дээврийн засварыг гүйцэтгэж дууссан. Барилгын гадна талын засварын ажил эхлээгүй байна. | |
| 12 | | 1.1.12. Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн засварт аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2023 онд 100.0 сая төгрөг, сумын ОНХС-аас 330.0 сая төгрөг, нийт 430.0 сая төгрөг төсөвлөгдөж, тендер зарлагдаад явж байна. | |
| 13 | | 1.1.13. Өлзийт сумын хуучин эмнэлгийн барилгын их засвар | | Засварын ажлын хэрэгжилтийн хувь | 100 | | Өлзийт сумын хуучин эмнэлгийн барилгын их засварын ажлыг “Густокеи” ХХК аймгийн ОНХС-ийн 150.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн, 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулсан. | |
| 14 | 1.2. Идэвхтэй | 1.2.1. Монголын | | Оролцогчдын | 1000 | | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амьдрал - Чийрэг иргэн | хүүхдийн спортын VII наадам зохион байгуулах | | тоо | | | дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Наадам зохион байгуулах аймаг хотыг сонгон шалгаруулах эрх олгох” шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж Монголын хүүхдийн спортын зуны VII наадмыг анх удаа орон нутагт буюу Баянхонгор аймагт зохион байгуулах эрхийг авч 2023 оны 01 дүгээр захирамжаар зохион байгуулах ажлын хэсэг, орон нутгийн зүгээс гаргах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, тус наадмыг зохион байгуулах дэд хороодыг 2023 оны 246 дугаар захирамжаар 13 дэд хороодын бүрэлдэхүүнтэй томилон 2023 06 дугаар сарын 19-29 өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 15 | | 1.2.2. Улс тив дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад дэмжлэг үзүүлэх | | Дэмжлэг үзүүлсэн тамирчдын тоо | 6 | | Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 57.0 сая төгрөг тусгаж 2023 оны VI -д оруулахаар төлөвлөж байна | |
| 16 | | 1.2.3. Клубуудын улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 250 | | Баянхонгор аймагт 2023 оны 02 дугаар сарын 26-03 дугаар сарын 05-ны хооронд клубүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг Усан бассейн спорт цогцолборт зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Улаанбаатар хотын клубуудээс эрэгтэй 4 , эмэгтэй 6 баг оролцож нийт 160 тамирчид оролцсон. | |
| 17 | | 1.2.4. Бууцагаан сумын Баянбүрд багт Спорт заалны барилгын ажил | | Гүйцэтгэлийн хувь | 50 | | Бууцагаан сумын Баянбүрд багт Спорт заалны барилгын угсралтын ажлыг гүйцэтгэгчээр "Оюут хайрга" ХХК гэрээ байгуулан ажлыг 2022 онд эхлүүлсэн. Барилга угсралтын гүйцэтгэл 80%-тай үргэлжилж байна. Тус ажил нь 2023 оны 08 сард ашиглалтад оруулна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | | 1.2.5. Бөмбөгөр сумын спорт заал бүхий багийн хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл ажил | | Гүйцэтгэлийн хувь | 50 | | Бөмбөгөр сумын спорт заал бүхий багийн хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. | |
| 19 | | 1.2.6. Дөвөнтийн заалны их засвар хийх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Дөвөнтийн заалны их засварын ажлын гүйцэтгэгчээр "Буян арвижих од" ХХК шалгарч, 2022 оны их засварын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 оны 12 сард улсын комисс ажиллан байнгын ашиглалтад оруулсан. | |
| 20 | | 1.2.7. Номундалай цогцолбор сургуулийн гадна спорт талбай байгуулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | "Баянхонгор-Эко" ХХК тендэрт шалгарч газрыг тэгшлэх ажлыг хийсэн. Нийт 1.3 тэрбум төгрөгийн өртөгтэй үүнээс 240.000.000 төгрөгийг шийдвэрлэж хөлбөмбөгийн талбайг ашиглалтад оруулхаар төлөвлөж байна | |
| 21 | 1.3. Боловсролын чанар хөгжлийн тулгуур | 1.3.1. Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах | | Бэлтгэгдсэн ажилтны тоо, Ажлын байраар хангагдсан хувь | 400<br>50 | | 2023 оны 1 сард 2,5 жилтэй 13 мэргэжлийн 246 суралцагч төгссөн бөгөөд үүнээс 43,5 % нь ажлын байраар хангагдаж үүнээс барилгын салбарт /Барилгын өргөгч угсаргач , Барилгын засал чимэглэл , Мужаан, Сантехник, Цахилгаан/ 18.2 хувь, үйлчилгээний салбарт /Үсчин, Авто засвар , Хоол үйлдвэрлэл, Ардын гоцлол хөгжим/ 19,9 хувь, Хөнгөн үйлдвэрлэлийн салбар /Оёдол/-5.2 хувь байна. 2023 оны 4, 5 сард 45 хоногийн түр сургалтыг Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран зохион байгуулж 7 мэргэжлээр 145 хүн хамруулан үнэмлэх олгосон. Үүнээс 75% нь ажлын байраар хангагдсан. | |
| 22 | | 1.3.2. Баян-Овоо сумын дотуур байрны их засварын ажлыг | | Засварын ажлын явц,хувиар | 100 | | Их засварын ажлын гүйцэтгэгчээр “Есөн-Од” констракшин 2020 онд 100 сая төгрөгөөр нийт ажлын 70 хувийг гүйцэтгэж 2023 онд 149 сая | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглалтад оруулах | | | | | төгрөгөөр 100 хувь гүйцэтгэж 2023 оны 06 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | |
| 23 | | 1.3.3. Баянговь сумын сургуулийн дотуур байрны их засвар | | Засварын ажлын явц,хувиар | 70 | | Их засварын ажлын гүйцэтгэгчээр “Содон сондор цамхаг” ХХК шалгарч, нийт өртөг 576 сая төгрөг. Үүнээс Баянговь сумын орон нутгийн хөгжлийн сангаас 100 сая төгрөг, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаасс 476 сая төгрөгөөр 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хийхээр гэрээ байгуулсан 2023 оны 5 сарын байдлаар ажил  эхлээгүй байна. | |
| 24 | | 1.3.4. Заг сумын сургуулийн дотуур байрны гадна пасад, дулаалга хийх | | Засварын ажлын явц,хувиар | 100 | | Дотуур байрны гадна пасатны дулаалга, засварын ажлын гүйцэтгэгчээр “Хийморь орд ” констракшин шалгарч аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан ажил одоогоор эхлээгүй байна. | |
| 25 | | 1.3.5. Галуут сумын Номун элч сургуулийн дотуур байрны засвар | | Засварын ажлын явц,хувиар | 100 | | Сурагчдын дотуур байранд засвар хийх ажлын саналыг аймгийн холбогдох хэлтэст хандсан боловч хөрөнгө төсөв тодорхойгүй тул одоогоор тендер зарлагдаагүй байна. | |
| 26 | | 1.3.6. Галуут сумын Мандал багийн сургуулийн дотуур байрны засвар | | Засварын ажлын явц,хувиар | 100 | | Төсөв, хөрөнгө мөнгөний асуудал тодорхой бус байгаа одоогоор ажил эхлээгүй. | |
| 27 | | 1.3.7. Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Богд сумын ЕБС-ийн 320 хүүхдийн хичээлийн байрны гадна пасадны засварыг “Түйн долгио” ХХК 2022 оны 05 дугаар сарын 07-31-ний хооронд хийж гүйцэтгэсэн. Барилгын гадна пасатны засварын нийт өртөг 158.782.345₮, үүнээс 2022 онд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 75.400.000₮ авсан. 2023 онд 83.382.346 төгрөгийн санхүүжилт үлдсэн байна. 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 2022/11 тоот барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарч хүлээлгэн өгсөн болно. | |
| 28 | | 1.3.8. Бууцагаан сумын хуучин сургуулийн дээврийн их засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Тендерт АЛЕГРОТОВЕР ХХК- шалгарч 2022 оны 5 сараас засварын ажил эхэлсэн. Бууцагаан сумын хуучин сургуулийн барилгын дээврийн их засварын ажил 100 хувь хийгдэж дууссан. | |
| 29 | | 1.3.9. Жаргалант сумын сургуулийн их засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Сургуулийн гал тогоо, агуулахын их засварын ажлыг "Ерөөл нэмэх' ХХК аймгийн Засаг даргын 2022 оны 48 дугаар тоот гэрээнд үндэслэн гүйцэтгэсэн. Ажил гүйцэтгэх явцад захиалагчийн хүсэлтээр сантехник халаалт, бохир усны систем, агааржуулалтын системийн ажлуудыг нэмэлтээр гүйцэтгэсэн. Хаалга цонх солих, хана шалны пильта наах болон бусад дотоод засварын ажлууд хийгдсэн. | |
| 30 | | 1.3.10. Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуульд Лингафонны танхимын тоног төхөөрөмж | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Аймгийн Засаг даргын захирамжаар Баацагаан сумын ЕБС-ийн Лингафонны танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг сумын Засаг даргын Тамгын газарт эрхийг шилжүүлсэн, тендер зарласан. | |
| 31 | | 1.3.11. Баянхонгор сумын 4-р цэцэрлэгийн их засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | "Жаргантайн хөх тариа" ХХК-тай 2022 онд шууд гэрээ байгуулан ажиллаж шал хуулах, хана цэвэрлэх дотор ажил хийгдэж ангиудын шалыг цементлэн хаалга, цонх, цахилгаан, сан техник, гал тогооны агааржуулалт, ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж комисс хүлээн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авсан. Гадна талбайн тохижилт 2023 онд хийгдэж эхлээд байна. | |
| 32 | | 1.3.12. Баянхонгор сумын 5,12-р цэцэрлэгийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Баянхонгор сумын 5, 12 дугаар цэцэрлэгийн засварын тендерт “Буян Арвижих” ХХК шалгарсан. Тендерт шалгарсан компани 04 дүгээр сарын 18 -нд байгуулсан 2023 оны 07 дугаар сарын 20-нд ажлаа хийж гүйцэтгэхээр аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулж 5 дугаар цэцэрлэгийн цэвэр бохир ус, халаалтын системийн ажлыг хийж эхлээд байна. | |
| 33 | | 1.3.13. Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Барилгын дээрийн их засварын гүйцэтгэгчээр "Илбата"ХХК шалгарсан гэрээ байгуулж эхний ажлаа эхлээд байна. | |
| 34 | | 1.3.14. Баян-өндөр сумын цэцэрлэгийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Цэцэрлэгийн гадна пасадны ажил иж бүрэн болон дээврийн их засварын тохижилт" нэртэй тендер зарлаж Төсөв-127,283,380 /аймгийн ОНХС-аас 50 сая, сумаас үлдсэн төсвийг/ т 2 компани оролцсноос "Буянт наран хөрс" ХХК шалгарч сумын Засаг даргатай гэрээ байгуулсан 2023 оны 05 сараас - 07 сар хүртэл 60 хоног /сумын Засаг даргатай гэрээ байгуулсан/. | |
| 35 | | 1.3.15. Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар тохижилт, хүүхдийн тоглоомын талбайн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Хуучин барилгын засварын ажлыг “Түйн долгио” ХХК нь 2023 оны 05 сарын 19 ны өдрөөс эхлэн 30 нийг хүртэлх хугацаанд 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн. Мөн гадна талбайн тоглоомын завсарын ажил нь барилгын завсарын төсөвтэй хамт суугдаагүй учраас зөвхөн барилгын гадна засвар хийгдсэн болно. | |
| 36 | | 1.3.16. Ариун цэврийн байгууламжийн тоог | | Ариун цэврийн байгууламжийн | 26 | | Богд, Гурванбулаг, Хүрээмарал, Жаргалант, Шинэжинст сумын сургууль, цэцэрлэг, дотуур | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх | | тоо | | | байрны ус ариун цэврийн байгууламжийн ажлын худалдан авах ажилаллагаа зохион байгуулагдаагүй, зураг төслийн ажил хийгдэж байна. | |
| 37 | 1.4. Шинжлэх ухаан технологи, инноваци | 1.4.1. Шинжлэх ухаан технологийн аймгийн зөвлөл, судалгааны баг ажиллуулж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, шинэ патент, грант олгох | | Шинэ патент, грантын тоо | 5 | | Аймгийн Засаг даргын "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах тухай" 2023 оны А/196 захирамжийн нэгдүгээр хавсралтаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Хоёрдугаар хавсралтаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн дүрмийг тус тус баталсан. Шинжлэх Ухаан Технологийн Үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан “Монголын инновацийн 7 хоног-2023” арга хэмжээ, “Инновацийг орон нутагт” сэдэвт мэргэжил, арга зүйн семинарт аймгийн Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар оролцлоо. Грант олгох үйл ажиллагаа 8 сард болно. | |
| 38 | | 1.4.2. Хүрэн Бэлчир, Чин сүжигт номун ханы хийд, Хүрээмарал сум дээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | | Жуулчдын тоо | 20000 | | “Эрдэнэ засгийн хошуу- Хүрэн Бэлчир”, “Дашдоо гүнийн хошуу- Чин сүжигт номун ханы хийд”-ийн түүх соёлын судалгаа нэртэй цуврал Эрдэм шинжилгээний хурлыг Түүхийн шинжлэх ухааны хүрээлэн, Архивын ерөнхий газар, Үндэсний төв архив зэрэг газруудтай хамтран 10 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулах, ажлын хэсэг, хөрөнгийн асуудлыг аймгийн Засаг даргын 2023 оны А/194 дүгээр захирамжаар баталж, хурлын урилга, удирдамжийг бэлтгэн нийт 53 судлаачид хүргүүлж бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 1.5. Халамжаас-Хөдөлмөрт | 1.5.1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх | | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 1310 | | Нийтийн эзэмшлийн газрын шороо бүхий талбайг эко хавтан, замын бродюр, явган замын хавтангаар бүрэх, ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, шинэ суурьшлийн бүс болон хотын төвийг тойрсон ойн зурвас, шинээр байгуулагдаж буй ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа хийх ажилд бүртгэлтэй, ажилгүй 364 иргэнийг түр ажлын байраар, 51 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, нийт 415 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан. | |
| 40 | | 1.5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх | | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 1800 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 64 төсөл хүлээн авч хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч 21 иргэнд 104.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Бичил бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 30-аас дээш настай иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг журмын дагуу сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. Нийтийг хамарсан, бүтээн байгуулалтын ажилд ажил идэвхтэй хайгч 364 иргэнийг хамруулж, түр ажлын байраар хангасан. | |
| 41 | | 1.5.3. Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангах | | Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо | 6380 | | Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч 5970 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулж, нийгмийн баталгааг нь хангасан. | |
| 42 | | 1.5.4. Зорилтот бүлгийн иргэдэд ажил | | Ажлын байранд зуучилсан | 2500 | | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөөнд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах | | иргэдийн тоо | | | зорилтот бүлгийн 105 /үүнээс эмэгтэй 78/ иргэнд зөвлөгөө өгч, 97 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний бүлгийн зөвлөгөөнд 8 удаа 364 иргэн хамрагдаж, мэдээлэл, зөвлөгөө авч түр ажлын байранд зуучлагдсан. | |
| 43 | | 1.5.5. Нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах | | Цахимжсан хувийн хэргийн тоо | 12877 | | Аймгийн хэмжээний нийт 12851 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг цахимжуулсан. Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулахад Хөгжлийн төлөвлөгөө хээрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 7.5 сая төгрөг зарцуулсан. | |
| 44 | | 1.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл,Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс,Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл, Жендэрийн салбар хорооны  үйл ажиллагааг дэмжих | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл,Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжихэд 9.0 сая төгрөг батлуулж, дэмжиж ажиллаж байна. Салбар зөвлөл болон комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 60 хувьтай байна. | |
| 45 | | 1.5.7. "Хүмүүнлэгийн ордны үйл ажиллагааг дэмжих | | Үйлчлүүлэгчдийн тоо | 800 | | Хүмүүнлэгийн ордны үйл ажиллагааны зардалд Орон нутгийн төсвөөс 110.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж байна. Хүмүүнлэгийн ордонд хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн суурь үйлчилгээ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзүүлэх 17 газар үйл ажиллагаагаа явуулж, давхардсан тоогоор 428 иргэн эрүүл мэндийн болон сэтгэл засал, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ авсан байна. | |
| 46 | 1.6. Соёлтой иргэн- Нийгмийг түүчээлнэ | 1.6.1. Түүх соёлын дурсгалт газар, соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэх, сурталчлах, дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 200 | | Түүх угсаатны зүй-байгалийн түүхийн музейн сан хөмрөгийг байгалийн үнэт чулууны цуглуулгаар үзмэрийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамж гаргаж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн. Уртын дууны сургалтыг сарын хугацаанд зохион байгуулж 15 хүн хамруулсан. 2.Аймгийн уртын дууны Улсын уралдаанд 4-н оролцогч бэлтгэж оруулснаас 1 хүн 3-р байрт эзэлсэн амжилттай байна. 3. Өвлөн уламжлагч ардын дууч Хоролсүрэнгийн бие даасан тайлан тоглолтыг 5 сарын 20 нд зохион байгуулж бүрэн хэмжээний тоглолт сумын соёлын төвд ХДТын ардын хөгжмийн хамтлагтай хамтарч зохион байгуулсан. | |
| 47 | | 1.6.2. Аймгийн зохиолчдын "Хонгорын дуун" утга зохиолын өдөрлөг зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 112 | | "Хонгорын дуун" утга зохиолын наадмыг VII сард зохион байгуулахаар төлөвлөж зардлыг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнийзардлаас 5.0 сая төгрөгийг төсөвлөсөн | |
| 48 | | 1.6.3. Заг Байдрагийн Хүрэн Бэлчирт Монгол туургатны харвуул их наадам зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 300.0 | | Аймгийн Засаг даргын 2023 оны А/177 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилж VII сарын 19-21 -ний өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна | |
| 49 | | 1.6.4. Хөгжимт драмын театр, Хүүхдийн | | Тоног төхөөрөмжийн | 100 | | Тендер зарлаж “Ээлгранд” ХХК шалгаран гэрээ байгуулан Хөгжимт драмын театрт нийлүүлэгдэх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тэмүжин театрын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг шинэчлэх | | шинэчлэлийн хувь | | | яригч, гэрэлтүүлгийн багц тоног төхөөрөмжийг 2023 оны А/67 дугаартай АЗДТГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон хүлээж авсан, Хүүхдийн Тэмүжин театрт үзэгчдийн сандлыг гүйцэтгэгч компаны гэрээг сунгах тухай хүсэлтийг харгалзан 6 дугаар сард багтаан хүлээн авахаар шийдвэрлэсэн. | |
| 50 | | 1.6.5. Баацагаан сумын соёлын төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 80 сая төгрөгний урсгал засвар хийгдэх тендер зарлагдаж байна. | |
| 51 | | 1.6.6. Баянлиг сумын соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмж | | 0 | 100 | | Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг Дэвших болор ххк-тай гэрээ байгуулсан. | |
| 52 | | 1.6.7. Баянлиг сумын соёл төвд шаардлагатай техник хэрэгсэл | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Техник хэрэгсэл нийлүүлэх гэрээг "Чүгма далай" ХХК  -тай байгуулсан | |
| 53 | | 1.6.8. Хүрээмарал сумын соёлын төвд шаардлагатай техник хэрэгсэл | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Соёлын төвд шаардлагатай техник хэрэгсэл нийлүүлэх гэрээг "Чүгма далай" ХХК-тай байгуулж 06 сард нийлүүлэхээр төлөвлөгдөж байна | |
| 54 | | 1.6.9. Хүрээмарал сумын соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмж | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээг Дэвших болор ХХК-тай байгуулж 06 сард нийлүүлэхээр төлөвлөгдөж байна. | |
| 55 | 1.7. Хонгорын иргэн- | 1.7.1. Аймгийн Хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах | | Чуулганаас гарсан саналын шийдвэрлэлтийн | 90 | | Аймгийн Хүүхдийн нэгдсэн чуулган нь жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулагддаг. Хугацаа болоогүй. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хонгорын баялаг | | | хувь | | | | |
| 56 | | 1.7.2. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх | | Угийн бичиг хөтлөлтийн хувь | 10 | | Аймгийн хэмжээнд нийт 5000 өрх угийн бичиг хөтлөхөөс 2023 оны хагас жилийн байдлаар 185 өрх буюу 19 хувьтай байна | |
| 57 | | 1.7.3. Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжих | | Үйлчлүүлэгчдийн тоо | 200 | | Хуримын ордон ашиглалтад орсноор “Гэр бүл, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх” өрөөг тохижуулан ажиллаж байна. 2023 оны 6 сарын байдлаар нийт 81 иргэнд зөвлөгөө мэдээлэл, ганцаарчилсан уулзалтыг хийснээс 30 нь насанд хүрээгүй иргэн, 51 нь насанд хүрсэн иргэн байсан ба 21 нь эрэгтэй байна. Өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 3 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн төсвөөс гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 50 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх тэндерийг зарласан. | |
| 58 | | 1.7.4. "Өвгөнжаргалант" зусланг түшиглэн амьдрах ухаан, хөдөлмөр зусланг бий болгох | | Зуслан ажиллуулсан сумын тоо | 3 | | Өвгөнжаргалант зуслангийн 9 дүгээр ээлжийг Хөдөлмөр зуслангийн хүрээнд хөгжлийн хөтөлбөр боловсруулан баталсан. Сумдад албан тоотоор хамтран ажиллах чиглэл хүргүүлсэн. Хөдөлмөр зусланг хэрэгжүүлснээр хүүхдэд эх оронч үзэл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлнэ. | |
| 59 | | 1.7.5. Алслагдсан сум, багийн малчдад зориулсан соёл хүмүүжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулах | | Арга хэмжээ зохион байгуулсан сумын тоо | 10 | | Орон нутгийн 19 сумын иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчилах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ажлыг зохион байгуулахын зэрэгцээ залуу, дунд насны гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, тогтвортой бат бөх гэр бүлийг төлөвшүүлэх, хүүхэд, иргэд, олон нийтийг хүүхэд хамгааллын талаар мэдлэгжүүлэх, нийгмийн сэтгэл зүйд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага төлөвшүүлэх, зөрчил мэдээллийг хүлээн авч газар дээр нь шуурхай шийдвэрлэх, хуулиар хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээгчдийг ажлын байранд нь чадавхижуулах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хамгаалах үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих, хүүхдийг эрсдэлд нөхцөлд оруулж болзошгүй орчны аюулгүй байдалд үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг газар дээр нь очиж, түргэн шуурхай шийдвэрлэх, зөвлөн туслах зорилгоор “Амар тайван гэр бүл” нэгдсэн өдөрлөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газартай хамтран 20 сумд зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд нийт иргэдэд чиглэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн 11 сургалт, хэлэлцүүлэг, үүрэг хүлээгчдэд чиглэсэн 1 сургалт, хүүхдүүдрүү чиглэсэн эх оронч үзэл төлөвшүүлэх, сайн дурын ажилд уриалах, үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах чиглэлээр 3 сургалтыг тус тус зохион байгуулсан. | |
| ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 60 | 2.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад | 2.1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90-ээс дээш хувьд хүргэх | | Төлбөрийн баримт олголтын хувь | 90 | | Татварын хэлтсийн даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/27 дугаар тушаалаар байгуулагдсан НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, тус аймагт худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн аж ахуй нэгжийн Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд холбогдсон, холбогдоогүй татвар төлөгчдийн судалгааг сум тус бүрээр нарийвчлан гаргаж, үйл | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | анхаарна. | | | | | | ажиллагаа явуулж байгаа эсэх байдалд хяналт тавьж, мэдээллийг шинэчлэн, татвар төлөгчдийн бүртгэлд нэмэх, хасах ажлыг гүйцэтгэж байна. Аж ахуйн нэгж, иргэдийг сегментээр ангилж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн танхимын 6 удаагийн, цахим 4 удаагийн сургалтад 116 татвар төлөгчийг хамруулллаа. Татварын хэлтсийн фэйсбүүк хуудас болон цахим хуудсаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн мэдээ, мэдээллийг сурталчлан ажиллаж байна. “Энд төлбөрийн баримт олгоно” наалтыг 1500 ширхэгийг хэвлүүлж аймгийн төвийн болон 19 суманд үйл ажиллагаа явуулж байгаа цэгүүдэд байршуулж байна. Мөн “Нэмэгдсэн өртгийн албан татвар” нэртэй, 18 хуудас бүхий гарын авлага хэвлэж, 350 ширхэгийг тараалаа. НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор аймгийн Прокурорын газартай хамтран Баянхонгор суманд 2023 оны 03 дугаар сард хамтарсан хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлж, 45 объектод шалгалт хийснээр 17 зөрчил илрүүлж, 7 иргэнд 4.9 сая төгрөгийн торгууль ногдууллаа. Тайлант хугацаанд иргэдээс татварын албаны тусгай дугаарын 1800-1288 утас болон и-баримт аппликейшнээр дамжуулж, 80 гомдол, мэдээллийг ирүүлсэн бөгөөд гомдлын дагуу иргэдэд баримтыг нөхөн олгуулж, 56 газарт мэдэгдэл, 22 газарт шаардлага өгч, 2 иргэнд 777280 төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийг арилгуулсан. | |
| 61 | | 2.1.2. Санхүүгийн эрсдэл бүхий 2 байгууллагад дотоод аудит, 4 суманд | | Эрсдэл өндөртэй байгууллагын | 18 | | Аймгийн Засаг даргын 2023 оны А/269 дүгээр захирамжийн дагуу Заг сумын төсөвт 6 байгууллагын 6,8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аймгийн Засаг даргын нэрэмжит зөвлөн туслах ажлыг зохион байгуулах | | тоо | | | танилцан түүврийн арга ашиглан тооллогыг хийж, сумын ЗДТГазарт 12 нэрийн 135,2 сая төгрөгийн хөрөнгийг нэр төрлөөр задлан бүртгэх, мөн ЗДТГ үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй дутагдуулсан 90 сая төгрөгийн өртөгтэй Японы дизель мотор, ЕБСургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 ширхэг сагсны шийдийг хувь хүмүүст ашиглуулж байгааг холбогдох арга хэмжээг авч хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөн туслаж ажилласан. | |
| 62 | 2.2. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн | 2.2.1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | | Гүйцэтгэлийн хувь | 80 | | Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулахаар ажиллаж байна. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилгын ажлыг 2021 онд тендер сонгон шалгаруулалт зарлан “Базарь дарь” ХХК шалгаран барьж 2022 онд үйлдвэрийн барилгыг хүлээлгэн өгсөн. Цаашид тус үйлдвэрийн үйл ажиллагааг Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГазар хариуцан ажиллах юм. Тус төслийн нийт төсөв 3,8 тэрбум. Мах ногооны зоорь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж Сант-Өндөр ХХК шалгарч барилгын ажлыг эхлүүлж, 2021 онд 250 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2022 онд санхүүжилт олгогдоогүй. Тус мах, ногооны зоорь 2024 онд ашиглалтад орно. Хөдөө аж ахуйн цогцолборын үйлдвэрлэлийн бүсийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажилд “Алтай эколос” ХХК, цахилгааны эх үүсвэрийн материал нийлүүлэх ажилд “Эн ди эм | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эм" ХХК, гадна холбооны шугамын материал нийлүүлэх ажилд "Нью Бест хаус" ХХК тус тус шалгарч дээрхи ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. 2022 онд 850 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон. 2023 онд 823.7 сая төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс авсан байна. | |
| 63 | | 2.2.2. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | | Гүйцэтгэлийн хувь | 70 | | Хөдөө аж ахуйн кластер төсөл:1-р багц-"Татах хүч" ,ХХК 500тн багтаамж бүхий зоорь, агуулахын хундамын цутгалтын ажил хийгдэж байгаа 9 сард хүлээлгэж өгнө. 2-р багц-"Номгоны андууд"ХХК, Баацагаан сумын 50 га, Хүрээмарал сумын 20 га , Өлзийт сумын Бумбатын 50 га талбайг тус тус хаших ажил хийгдэж байна, бусад сумдын гүйцэтгэл хийгдэж дууссан. 3-р багц-"Гарьд системс" ХХК, цахилгааны 2023 оны Баянлиг сумд цахилгааны под станц хүлээгдэж байна. Төсвийн багц нь хүрэлцээгүй учраас 2024 он хүртэл хойшлоод байна 4-р багц "Эм эн юу" ХХК-Дундын үйлчилгээний багж тоног төхөөрөмж 8 нэр төрлийн 11 тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. 5-р багц-"Гичгэнэ хяр" ХХК- Өлзийт сумын Улаан-Уул 6-р багийн нутаг дэвсгэрийн 4 га талбайд хашаажуулалтын ажил 90 хувьтай явагдаж байна. 6-р багц: 4 улирлын 2 хүлэмжийн тендер зарлагдсан боловч оролцогч компаниас сангийн яамруу гомдол гаргасан тул дахин зарлагдах шатандаа явна. | |
| 64 | | 2.2.3. Ингэний сүүний үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 6 багц ажил, арга хэмжээний тендер зарлагдан хэрэгжиж байгаа бөгөөд үүний нэг болох Ингэний сүүний үйлдвэрийг байгуулах ажил нь үйлдвэрийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | барилгын ажлыг барьж хүлээлгэн өгсөн. Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/7 тоот тогтоолоор "Ингэн эрдэнэ" ОНӨААТҮГ байгуулж ингэний сүүний үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах, гадаад дотоод зах зээл, фермер байгуулах зэрэг ажлыг БНХАУ, Өмнөговь аймгуудаас туршлага судлан ажиллаж байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн захиалгыг БНХАУ-н тоног төхөөрөмж нийлүүлэгч ААН-д өгөх, нийлүүлэх, угсрах ажил хүлээгдэж байна. 2023 онд улсын төсвөөс 165,0 сая төгрөг зарцуулсан. | |
| 65 | | 2.2.4. Хангайн бүсийн тогооч нарын ажил мэргэжлийн уралдаан, урлаг спортын наадам зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 100 | | Баянхонгор аймгийн Засаг даргын нэрэмжит “Өнгүүр буурч цом-2023 ”Баруун бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, спортын нөхөрсөг тэмцээнийг 2023 оны 05 сарын 12-13 ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгууллаа. Тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, Монголын тогооч нарын холбоо, Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо ажиллаж, Аймгийн ХХААГ, БШУГ, БОАЖГ, БТСГ, СХЗГ, ЭМГ, Политехник коллеж, МҮХАҮТ-ын салбар, Эрчим хүч ТӨҮГ, зэрэг хэлтэс агентлаг, байгууллагууд хамтран ажиллалаа.Тус тэмцээнийг аймгийн хөжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10 сая төгрөгөөр санхүүжүүлж, баруун бүсийн аймгууд болох Баян- Өлгий, Завхан, Говь-Алтай, Ховд, Увс, Баянхонгор аймгуудын Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажилладаг 150 орчим тогооч, дагалдах албаны хүмүүс, дасгалжуулагчдын хамтаар ирж 11 төрөлд өрсөлдөн шилдгүүдээ шалгаруулан урамшуулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Булган аймгийн Засаг дарга, Монголын тогооч нарын холбоотой хамтран зохион байгуулсан “Улсын залуу аварга тогооч-2023” уралдаанд 2023 оны 01 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд орон нутгийн залуу тогоочдыг хамруулан оролцлоо. Монгол Улсын залуу аварга тогооч шалгаруулах ур чадвар, ажил мэргэжлийн 12 дахь уралдаанд 17 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 215 залуу тогооч 4 төрөлд өрсөлдсөн бөгөөд Баянхонгор аймгаас “Орчин үеийн Монгол хоол”-ны төрөлд 18-29 насны ангилалд О.Сүмбэрэлзул Тэргүүн байр, “Орон нутгийн онцлог бүхий үндэсний хэв маяг уламжлал агуулсан брэнд хоол бүтээх төрөл”-д Баянхонгор Политехникийн коллежийн оюутан Б.Жавхлантөгс Тэргүүн байр, “Ганцаарчилсан гранпри” төрөлд тогооч Б.Балчин Гутгаар байр, “Багийн гранпри” төрөлд багаараа Тусгай байр буюу 4 төрөлд тус бүрт амжилттай оролцож байр эзэллээ. | |
| 66 | | 2.2.5. Хүн амын хүнсний хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлэх | | Нөөцөлсөн махны хэмжээ /тонн/ | 180 | | Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 180тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгж нь Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжын дагуу хийж байна. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2023 оны 04 дүгээр сарын 04-өөс 06 дугаар сарын сарын 04 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 80.0 сая төгрөгийг “Баянхонгор констракшн" ХХК-д олгох бөгөөд гэрээний дагуу 40.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. | | |
| 67 | | 2.2.6. Баянхонгор аймагт импортоор оруулж ирж байгаа,орон нутагт үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэж экспортонд гаргаж болох бараа бүтээгдэхүүний судалгааг гаргах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн зохион байгуулах | | Судалгааны тоо | 3 | | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас журам боловсруулан хийгдэхээр хүлээгдэж байна. | |
| 68 | | 2.2.7. Аймаг, орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор “НЭГ ӨРХ, НЭГ БАЙГУУЛЛАГА, НЭГ СУМ-НЭГ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН, | | Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо | 9 | | Аймгийн ИТХ-аас журам боловсруулагдан бүх сум, байгууллагуудад хүргэгдэхээр хүлээгдэж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ҮЙЛЧИЛГЭЭ” шалгаруулах болзолт уралдаан зарлаж, шалгарсан бүтээгдэхүүнүүдийг бодлогоор дэмжих | | | | | | |
| 69 | 2.3. Эрүүл хөрс-Эрүүл хүнс | 2.3.1. Сарлаг үхэр , баталгаажсан үйлдэр омгийн хээлтэгч малд шилэн сонголт хийх | | Шилэн сонголтод хамрагдсан малын тоо /мянга/ | 11 | | Хаврын техонлогит хугацаанд баталгаажсан үүлдэр омгийн мал сүрэгт үзлэг ангилалтын ажил явагдаж байна. Баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг ангилалтын ажлыг зохион байгуулах зорилгоор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт болох 18,0 сая төгрөгний асуудлыг шийдвэрлүүлээд байна. Ламын гэгээний улаан үржлийн хэсгийн тэмээ 200 толгой, Залаажинст-Эдрэн үүлдрийн 354 ямаа, Бөмбөгөрийн улаан омгийн 531 ямаанд үзлэг ангилалт хийгдсэн. Мөн Баянбулаг омгийн 900 хонинд хийгдсэн | |
| 70 | | 2.3.2. Бод малд зохиомол хээлтүүлгийн туршилт, судалгаа хийх | | Зохиомол хээлтүүлэг хийсэн малын тоо | 100 | | Энэ онд 100 толгой хээлтэгчид зохиомол хээлтүүлэг хийхээр ажлын төлөвлөгөөг гарган бэлтгэл ажлыг хангаж байна. Зохиомол хээлтүүлэг хийх хээлтэгчийг сонгох, үр авах ажил хийгдэж байна. | |
| 71 | | 2.3.3. Шаардлагатай сумдын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж худаг гаргах, засварлах | | Шинээр гаргах худгийн тоо, засварласан худгийн тоо | 7 1 | | Улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Богд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баацагаан, Богд, Гурванбулаг, Өлзийт сумын нутагт гүн өмрийн 4 худаг шинээр буюу сэргээн засварлахаар гүйцэтгэгч аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
